



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2010 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

Г “Моннис” ХХК-д ердийн даатгалын 7  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Даатгалын тухай хуулийн 13.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгал болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.39 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Моннис” ХХК-д дараах даатгалын хэлбэрүүдээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай:

- 1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал;
- 1.2. Хөрөнгийн даатгал;
- 1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал;
- 1.4. Ачааны даатгал;
- 1.5. Барилга угсралтын даатгал;
- 1.8. Агаарын хөлгийн даатгал;
- 1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал;
- 1.10. Хариуцлагын даатгал;
- 1.11. Санхүүгийн даатгал.

2. Даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Моннис” ХХК /С.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН